

ИНДЕКСЖҮҮЛСЭН ДААТГАЛЫГ ХӨГЖҮҮЛЭХ АРГА ЗАМ

Г.Бурмаа*, Я.Оюунсүрэн**

Хураангуй: Монголын эдийн засгийн нэг тулгуур бол хөдөө аж ахуй салбар юм. Монголын хүн амын тал хувь нь мал аж ахуй, газар тариалан эрхэлж, дотоодын нийт үйлдвэрлэлийн 36,1%-ийг хөдөө аж ахуйн гаралтай бүтээгдэхүүн эзэлж байна. Эрс тэс уур амьсгалтай ган зуд зэрэг байгалийн гамшиг элбэг тохиолддог манай орны нөхцөлд эрслийг бууруулах, ард иргэдийнхээ амжиргаа, улс орны эдийн засгийг тогтвортой байлгахын тулд хөдөө аж ахуйн салбарт даатгалын тогтолцоог хөгжүүлэх нь чухал ач холбогдолтой юм.

Түлхүүр үгс: малын индексжүүлсэн даатгал, газар тариалангийн индексжүүлсэн даатгал,

Оршил

Монгол улс 2005 оноос эхлэн мал аж ахуйн салбарт индексжүүлсэн даатгалыг хэрэгжүүлж эхэлсэн боловч 2016 оны статистик мэдээллээс харахад монгол улсын нийт 56 сая толгой малын 7,5%³ буюу 4,2 сая мал даатгалд хамрагдсан нь хангалтгүй юм. Харин газар тариалангийн салбарын хувьд даатгалын бүтээгдэхүүн зогсонги байдалд буюу 0%-тай байна. Хөдөө аж ахуйн даатгал нь байгалийн гамшиг гэнэтийн эрсдэл тохиолдсон жил даатгалын компаниуд их хэмжээний санхүүгийн хүндрэлд ордог эсвэл өнтэй сайхан жил болвол малчид, тариаланчид даатгалын үр шимээ огт хүртдэггүй шалтгаанаар даатгагч, даатгуулагчийн харилцан ашигтай байдлаар хөгжиж чадахгүй байх талтай байдаг. Тиймээс монголын хөдөө аж ахуйн салбарын өнөөгийн байдлыг судалж, энэ чиглэлд хөгжингүй орны туршлагаас монголын нөхцөлд тохиромжтой даатгалын оновчтой хувилбарыг сонгон хэрэгжүүлэх зайлшгүй шаардлагатай байгаа юм.

* МУИС-ийн Бизнесийн сургууль, (Email) fin_burmaa@yahoo.com

** МУИС-ийн Бизнесийн сургууль, (Email) ooyo.mgl@gmail.com

3 Хөдөө аж ахуйн давхар даатгал ХК

Индексжүүлсэн даатгалыг хэрэгжүүлэх хэрэгцээ шаардлага

Мал аж ахуй, газар тариалан нь даатгалын салбарын хувьд хамгийн эрсдэл өндөртэй гэж тооцогддог. Олон улсын чиг хандлагаас харахад учирч болох гамшиг эрсдэлээс хамаараад даатгалын төрөлжүүлэлтийг улирлын хөдөө аж ахуйн даатгал, бүс нутгийн хөдөө аж ахуйн даатгал, өндөр эрсдэлт хөдөө аж ахуйн даатгал, индексжүүлсэн даатгал зэргээр ангилж байна.

Индекс суурилсан зудын эсрэг даатгалын стандарт бүтээгдэхүүнийг Малын индексжүүлсэн даатгал гэнэ. Өөрөөр хэлбэл нэгж даатгуулагчийн хохирлыг төлөхдөө тухайн төрлийн даатгалын бүс нутгаарх хохирлын хэмжээ, хохирол учрахад нөлөөлсөн хүчин зүйлсийн хэмжээ зэрэг хохирлын шууд бус үзүүлэлтүүдэд тулгуурлан даатгалын нөхөн төлбөрийг төлдөг үндсэн зарчимтай даатгал юм. Өөрөөр хэлбэл даатгуулагчид учирсан малын хорогдлын бодит хэмжээ сумын дундаж малын хорогдлын хэмжээнээс илүү байж болох бөгөөд хэрэв сумын хорогдлын хэмжээ босго үзүүлэлтэд хүрээгүй бол нөхөн төлбөр авахгүй. Үүнтэй адилаар сумын дундаж малын хорогдлын хэмжээ босго үзүүлэлтээс давсан тохиолдолд даатгуулагчид аливаа малын хорогдол учраагүй байсан ч даатгуулагч нөхөн төлбөр авах болно. Дэлхийн улс орнуудад малыг индексжүүлсэн аргаар даатгаж байсан туршлага байхгүй тул манайд малын индексжүүлсэн даатгал төслийг 2005 оноос туршилтын журмаар, 2012 оноос үндэсний хэмжээнд хэрэгжүүлж байна.

Харин манай улс газар тариалангийн салбарт уламжлалт даатгалын төрлийг ашиглаж ирсэн бөгөөд энэ нь бодит мэдээлэлд тулгуурлаж хохирлыг баталгаажуулсны үндсэн дээр тодорхой хувийн нөхөн олговрыг буцаан төлөх замаар хэрэгжүүлдэг.

Газар тариалангийн эрсдэл нь ган, мөндөр, хаврын эцсийн болон намрын эхний цочир хүйтрэлт, хураалтын үеийн хур тундас, нойтон цас зэрэг байгалийн хүчин зүйлээс мөн үр сортын сонголт буруу, тариалалтын хугацаа, уринш боловсруулалтын төрөл зэрэг технологийн хүчин зүйл, мэргэжлийн боловсон хүчин, техникийн хүчин чадал зэрэг зохион байгуулалт хүний хүчин зүйлээс хамаарч бий болдог. Тиймээс манай орны газар тариалангийн салбарт учирч буй эрсдлийн төрлүүдийг харгалзан үзэж тохирох төрлийн даатгалын системийг хэрэгжүүлэх нь цаашид энэ салбарын хөгжил, тогтвортой байдалд чухал нөлөөтэй юм.

Бусад улс орнууд газар тариалангийн салбарт уламжлалт даатгал, гарцын даатгал, индексжүүлсэн даатгал гэсэн гурван төрлийг түлхүү хэрэгжүүлж

байна. Эдгээр төрлүүдийн давуу болон сул талыг харьцуулан үзэж монгол улсын цаг уурын нөхцөл байдал, газар тариалангийн салбарын хөгжил, хүн амын амжиргааны өрсөлдөх чадвар зэргийг харгалзан үзвэл манайд хэрэгжүүлвэл илүү оновчтой төрөл хэлбэр нь индексжүүлсэн даатгал байгаа юм. Индексжүүлсэн даатгалыг бусад улс орнууд гамшиг эрслийн хэд хэдэн тулгуур үзүүлэлтэд үндэслэн газар тариалангийн салбарт хэрэгжүүлж ирсэн бөгөөд харин монгол улс 2005 оноос анх удаа малыг индексжүүлэн даатгасан юм.


Хүснэгт 1. Индексжүүлсэн даатгалын төрөл

	Нэр	Тулгуур үзүүлэлт	Жишээ орнууд
1	Гарцын даатгал	Нэгж талбайн ургац алдалт	АНУ, Энэтхэг, Бразил
2	Ургамлын сангийн даатгал	Ургамлын сангийн тархалт	Мексик, Испани, Канад
3	Малын даатгал	Малын тоо толгойн хорогдол	Монгол
4	Гамшгийн даатгал	Нэгж талбайн хохирлын хэмжээ	Канад, АНУ
5	Цаг уурын даатгал	Цаг агаарын үзэгдлийн хэмжээ	АНУ, Канад, Мексик, Энэтхэг

Эх сурвалж: Agricultural insurance” Ramiro Iturrioz 2009 theWorldBank

Дэлхийн улс орнуудын хөдөө аж ахуйн индексжүүлсэн даатгалын бүтээгдэхүүний 90%-ийг газар тариалангийн даатгал эзэлж байна.

Зураг 1. Дэлхийн улс орнуудын хөдөө аж ахуйн даатгалын бүтэц



Эх сурвалж: Agricultural insurance” Ramiro Iturrioz 2009 theWorldBank

Тиймээс газар тариалангийн салбарт индексжүүлсэн даатгалыг бусад орны туршлагаас суралцан нэвтрүүлэх арвин боломж байгаа юм.

Индексжүүлсэн даатгалыг хөгжүүлэх арга зам

Монгол Улсын засгийн газар мал аж ахуйг эрсдэлээс хамгаалах шинэ тогтолцоог бий болгох зорилгоор 2005 оноос Дэлхийн банктэй хамтран Малын индексжүүлсэн даатгал төслийг хэрэгжүүлж эхэлсэн бөгөөд төслийг цаашид үргэлжүүлэх зорилгоор “Малын индексжүүлсэн даатгалын тухай хууль”-ийг 2014 онд баталсан. Одоо төслийн үйл ажиллагааг “Хөдөө аж ахуйн давхар даатгал” хувьцаат компани хариуцан малын индексжүүлсэн даатгалыг хэрэгжүүлж байна.

Зуд турхан, байгалийн гамшигт үзэгдлийн дараа малчдын амьжиргаа доройтдог эмзэг байдлыг бууруулж тогтвортой болгох, байгалийн гамшигийн үед төрд ирдэг ачааллыг хөнгөвчлөх, хохирлыг дан ганц төрөөс хариуцах биш тодорхой хэсгийг хувийн хэвшил, олон улсын давхар даатгалын хөрөнгийн эх үүсвэрээр арилгадаг олон улсын жишгийг даган зах зээлийн зарчмаар даатгалын тогтолцоог хөгжүүлэх нь индексжүүлсэн даатгалын гол ач холбогдол, онцлог чанар юм.

Монгол улсын байгаль цаг уурын байдлыг өнгөрсөн
70 жилийн хугацаагаар харуулбал:


Хулгана	Үхэр	Бар	Туулай	Луу	Могой	Морь	Хонь	Бич	Тахиа	Нохой	Гахай
				1940	1941	1942	1943	1944	1945	1946	1947
1948	1949	1950	1951	1952	1953	1954	1955	1956	1957	1958	1959
1960	1961	1962	1963	1964	1965	1966	1967	1968	1969	1970	1971
1972	1973	1974	1975	1976	1977	1978	1979	1980	1981	1982	1983
1984	1985	1986	1987	1988	1989	1990	1991	1992	1993	1994	1995
1996	1997	1998	1999	2000	2001	2002	2003	2004	2005	2006	2007
2008	2009	2010	2011	2012	2013	2014	2015	2016			

Цагаан - Өнтэй буюу хэвийн жил- 42 буюу 55%

Саарал - Ган, зудтай жил 34 буюу 45%

Монгол орны байгаль цаг уурын хүндрэл 50 хувийн эрсдэлтэй бөгөөд давтамжийг ажиглавал ган зуд нь 4-5 жил дараалан тохиолдох магадлалтай байдаг байна. Гамшигт үзэгдлийн улмаас мал аж ахуйн үйлдвэрлэлд малын тоо толгой хорогдох, төл бойжуулалт багасах, малын өвчлөл нэмэгдэх, сүргийн бүтэц алдагдах зэрэг үр дагавар үүсдэг бол нийгэм, улс орны эдийн засагт ядуурал, ажилгүйдэл нэмэгдэж, ард иргэдийн амжиргааны түвшин доройтох, дотоодын нийт бүтээгдэхүүний үйлдвэрлэлд нөлөөлж эдийн засгийн тогтворгүй байдлыг бий болгодог.

Зураг 2. Малын индексжүүлсэн даатгалын хамрагдал /аймгуудаар/



Эх сурвалж: Хөдөө аж ахуйн давхар даатгал ХК, 2016

Зураг 3. Малын индексжүүлсэн даатгалын хураамж, нөхөн олговрын хэмжээ



Эх сурвалж: Хөдөө аж ахуйн давхар даатгал ХК, 2016

2016 оны байдлаар хөдөө аж ахуйн давхар даатгал ХК малын индексжүүлсэн даатгалд 18,738 малчин даатгуулж, 1 тэрбум 774 сая төгрөгийн хураамж төвлөрүүлжээ. Мөн нийт 4,185,234 толгой мал МИД-д хамрагдсан нь манай улсын нийт 56 сая малын 7.47 хувийг, даатгалд хамрагдсан малчин өрхийн нийт малчин өрхөд эзлэх хувь нь 12,24% байна.⁴

Монгол улсын газар тариалангийн 94%-ийг дангаар эзэлдэг улаан буудайг манай улс 2016 оноос нэрлэсэн эрсдэлт даатгалын төрлөөр анх удаа

⁴ Хөдөө аж ахуйн давхар даатгал ХК

даатгаж эхлээд байна. Гэвч 2016-2017 онд газар тариалан эрхлэгч 1100 компаниас зөвхөн ганц аж ахуйн нэгж л энэхүү даатгалд хамрагдан гэрээ байгуулжээ.

Өнгөрсөн оны байдлаар газар тариаланг дэмжих зорилгоор төрөөс газар тариаланг дэмжих бодлогын хүрээнд 841 аж ахуйн нэгж, иргэнд 9,4 тонн шатахууныг онцгой албан татваргүй үнээр олгосон, 345 аж ахуйн нэгжид 12,1 мянган тонн улаан буудайн үрийг 30%-ийн урьдчилгаатай, 7,9 мянган тонн эрдэс бордоог 70%-ийн үнийн хөнгөлөлттэй олгож, Хөгжлийн банкны санхүүжилтээр 25,0 тэрбум төгрөгийн хөнгөлөлттэй зээлийг 90 гаруй аж ахуйн нэгжид олгожээ. Гэвч 2016 оны ургацад учирсан шууд хохирол 26 тэрбум төгрөгтэй тэнцэж байна⁵.

Хөдөө аж ахуйн салбар нь өөрөө байгаль цаг уурын хүндрэлтэй нөхцөл, техник технологи, хүний нөөцийн чадавхийн хүчин зүйлсээс ихээхэн хамаардаг өндөр эрсдэлтэй салбар учраас төдийлөн энэ салбарт үйл ажиллагаа явуулахгүй байна. Жишээ нь: газар тариалангийн даатгал хийхэд даатгалын компаниуд хяналт шалгалт хийх, хохирлыг үнэлэх зорилгоор тариан талбай дээр 4-5 удаа үйл ажиллагааны зардал маш өндөр, хохирлын үнэлгээ хийхэд цаг хугацаа, мэргэжлийн боловсон хүчин шаардлагатай байдаг бол даатгуулагч аж ахуйн нэгжийн зүгээс даатгалын хураамжийн хувь өндөр байгаа тариаланчдад даатгалын хураамжийг шууд төлөх бэлэн мөнгө байхгүй зэрэг шалтгаанаар газар тариалангийн салбарт даатгалын хөгжил зогсонги байдалд байна.

Төрөөс үзүүлж буй дэмжлэгүүд нь зөвхөн хөнгөлөлттэй зээл, үр тарианы урьдчилгаа, шатахуун өвс тэжээлийн тусламж зэргээр хязгаарлагдаж байгаа нь хөдөө аж ахуйн салбарын бие даасан бизнесийн хөгжлийг дорвитой дэмжэж чадахгүй байгаа юм. Хэрэв төр дэмжлэгээ тус салбарын даатгалын тогтолцоонд хандуулж эрхзүйн орчин, бодлогын түвшинд хөрөнгө оруулалт хийвэл байгалийн гамшиг, гэнэтийн эрсдэл зэргээс урьдчилан сэргийлэх, гамшгийн дараах хохирлыг нөхөн барагдуулахад бизнесийн салбар буюу даатгалын компаниуд, олон улсын даатгалын байгууллагуудад хариуцлагыг хувааснаар төсөвт ирэх ачааллыг багасгах чухал ач холбогдолтой.

Тиймээс газар тариалангийн гол бүс нутаг болох Сэлэнгэ, Дорнод, Төв аймгуудын тариалангийн сумдын олон жилийн ургацын түүхэн мэдээлэл, цаг уурын нөхцөл болох агаарын хэм, хур тунадасны хэмжээг үндэслэн цаг

5 ХХААХҮЯ

уурын нөхцөлийн нэгж талбайн ургацад нөлөөлөх нөлөөллийг судлан дараах дүгнэлтэнд хүрлээ.

Сэлэнгэ аймгийн Ерөө сумын улаан буудайн тариалангийн нийт талбай, ургацын хэмжээ болон тухайн жилийн агаарын дундаж хэм, хур тунадасны үзүүлэлтийн судалгааг дараах хүснэгтэнд харуулав.

Хүснэгт 2. Сумын нэгж талбайн ургац, цаг уурын мэдээлэл

Он	Ерөө сум					
	Талбай	Ургац	Нэгж талбайн ургац	Агаарын хэм	Хур тунадас 5-9 сар	Хур тунадас 6-8 сар
2007	5837	6614.5	1.133202	17.58211	53.78	78.633
2008	8117	14195.8	1.748897	16.16748	43.63	76.766
2009	11118.5	21293.4	1.915132	16.42114	47.566	75.933
2010	10148.6	13361.8	1.316615	16.81138	45.1	55.266
2011	12331.6	17798.9	1.443357	16.38862	49.05	51.7
2012	11475	18238	1.589368	15.76911	68.46	98.566
2013	12728	15645	1.22918	16.02927	52.1	74.9
2014	12248	25826	2.108589	15.32439	44.68	51.833
2015	11979	8648.4	0.721963	17.74553	46.32	61.233
2016	11166	18938	1.696042	16.75935	50.84	73.43

Эх сурвалж: Судлаачийн тооцоолол

Ерөө сумын хувьд нэгж талбайн ургацын хэм жээг тухайн онуудын агаарын хэм болон, хур тунадасны хэмжээнээс хамааруулж эконометрик үнэлгээг 5-9 сарын дунджаар мөн 6-8 сарын дунжийг оролцуулан үнэлэхэд хур тунадасны хэмжээ нэгж талбайн ургацын хэмжээнд хүчтэй нөлөөлөхгүй байгаа нь дараахи хүснэгтээс харагдаж байна.

Хүснэгт 2–ийн HUR_6 хувьсагчийн үнэлгээний T статистик болон магадлалын үзүүлэлтээс харахад ач холбогдол багатай байна.

Хүснэгт 3. Хур тунадас, нэгж талбайн ургацын үзүүлэлт

Dependent Variable: GROWTH_PER_SQ

Method: Least Squares

Date: 05/01/17 Time: 19:57

Sample: 2007 2016

Included observations: 10

Variable	Coefficient	Std. Error	t-Statistic	Prob.
C	8.366506	2.249007	3.720089	0.0075
TEMP	-0.414890	0.131018	-3.166673	0.0158
HUR_6	-0.000439	0.006708	-0.065453	0.9496
R-squared	0.589688	Mean dependent var		1.490235
Adjusted R-squared	0.472456	S.D. dependent var		0.408275
S.E. of regression	0.296539	Akaike info criterion		0.650049
Sum squared resid	0.615548	Schwarz criterion		0.740825
Log likelihood	-0.250245	Hannan-Quinn criter.		0.550468
F-statistic	5.030098	Durbin-Watson stat		1.873833
Prob(F-statistic)	0.044249			

Эх сурвалж. Судлаачийн тооцоолол

Иймд нэгж талбайгаас авах ургацын хэмжээ (GROWTH_PER_SQ) — ийг агаарын хэмээс хамааруулж үнэлсэн үнэлгээг дараах хүснэгтээр харуулав. Энэ нь агаарын хэм 1°C —ээр нэмэгдэхэд нэгж талбайгаас авах ургацын хэмжээ 0,414 тонноор буурах нь (Хүснэгт 3) харагдаж байна. Иймд нэгж талбайн ургацын хэмжээг агаарын хэмээс хамаарсан хамаарлын тэгшитгэлийг бичвэл:

$$\text{GROWTH_PER_SQ} = 8,32 - 0,414 * \text{TEMP} \quad (2.1)$$

Хүснэгт 4. Агаарын хэм, нэгж талбайн ургацын үзүүлэлт

Dependent Variable: GROWTH_PER_SQ

Method: Least Squares

Date: 05/01/17 Time: 20:02

Sample: 2007 2016


Included observations: 10

Variable	Coefficient	Std. Error	t-Statistic	Prob.
C	8.324906	2.018620	4.124059	0.0033
TEMP	-0.414227	0.122226	-3.389018	0.0095
R-squared	0.589437	Mean dependent var		1.490235
Adjusted R-squared	0.538117	S.D. dependent var		0.408275

S.E. of regression	0.277472	Akaike info criterion	0.450661
Sum squared resid	0.615924	Schwarz criterion	0.511178
Log likelihood	-0.253304	Hannan-Quinn criter.	0.384274
F-statistic	11.48544	Durbin-Watson stat	1.876581
Prob(F-statistic)	0.009514		

Эх сурвалж. Судлаачийн тооцоолол

Зураг 4. Нэгж талбайн ургац, агаарын хэмийн хамаарал



Эх сурвалж. Судлаачийн тооцоолол

Ерөө сумын нэгж талбайгаас авах ургацын дундаж 2007-2016 онуудын хувьд 1,49 тонн байна.

Индексжүүлсэн газар тариалангийн даатгалыг хэрэгжүүлэхэд агаарын хэм, хур тунадасны дундаж үзүүлэлтүүдийн нөлөөллийг хамт авч үзэх зорилт дэвшүүлсэн боловч хур тунадаснаас хамаарч ургацын хэмжээ өөрчлөгддөггүй болох нь судалгаа хийсэн сумдын хувьд ижил төстэй байна.

Хур тунадасны хэмжээ нэгж талбайн ургацад нөлөөлөх нөлөөллийг тухайн орон нутгийн жилийн ашигтай хугацааны нийт хур тунадасны хэмжээгээр тогтоодог жишиг олон улсад байдаг. Иймд судалгаанд хамрагдсан сумдын тариалалтын хугацааны ашигтай хур тунадасны нийлбэрийг олон жилийн

дунджаар тооцож үзэхэд 202-235мм, ашигтай хугацааны агаарын хэмийн олон жилийн дундаж 16,6 байна.

Дээрхи судалгааны дүнг үндэслэн монгол улсад газар тариалангийн цаг уурт суурилсан индексжүүлсэн даатгалыг хэрэгжүүлэх боломж, арга замыг дараах байдлаар санал болгож байна.

- Индексжүүлсэн даатгал нь монголын байгаль цаг уурын нөхцөл, иргэдийн амжиргааны түвшин, даатгалын салбарын үйл ажиллагаанд хамгийн тохиромжтой хувилбар гэдэг нь өмнөх малын индексжүүлсэн даатгалын туршлагаар батлагдаж байна.
- Монгол улсын зах зээлд тогтвортой хэрэгжих даатгалын бүтээгдэхүүнийг бий болгож, зөв менежмент, бага зардлаар хөгжүүлэхийн тулд төрөөс хууль эрхзүйн орчныг сайжруулан бие даасан хуулийг батлуулж, даатгалын тогтолцоог бүрдүүлэх шаардлагатай.
- Бодлого хэрэгжилтийн түвшинд малчид тариаланчдад даатгалын үйл ажиллагааны мэдээллийг хангалттай хүргэх, даатгалд хамруулах үйл ажиллагааг эрчимжүүлэх, ач холбогдлыг сурталчлах таниулах.
- Тариалангийн бүс нутгуудийн хувьд цаг уурын босго үзүүлэлтүүдийг тогтоон индексжүүлэх хэрэгтэй гэж үзэж байна.

Ашигласан материал

1. Бакей.А, “Хөдөө аж ахуйн эдийн засаг” Улаанбаатар 2014
2. Балж.Г, “Эрсдэл ба даатгал” Улаанбаатар 2002
3. “Даатгал” Болдбаатар.Д, Молом.Ц, Улаанбаатар 2000
4. “ХАА-н салбарын өрсөлдөх чадвар ба орон нутгийн хүн амын амжиргааны түвшин” судалгааны товхимол-10, 2015 Монгол банк
5. “Мал аж ахуйн даатгал” нэг сэдэвт бүтээл, 2002 М.Буяндэлгэр
6. “Төрөөс хүнс, хөдөө аж ахуйн талаар баримтлах бодлого батлах тухай” тогтоол
7. “Малын индексжүүлсэн даатгалын тухай хууль” 2014,
8. “Босго үзүүлэлт тогтоох тухай” 2015, Засгийн газрын тогтоол
9. “Хөдөө аж ахуйн даатгалын бодлого, тогтолцооны шинэчлэл” хэлэлцүүлэг, 2016 он
10. “Газар тариалангийн салбарт учирч буй эрсдэлийг бууруулах талаар төрөөс баримталж буй бодлого, өнөөгийн байдал” сэдэвт илтгэл, Ц.Болорчулуун
11. “Мал аж ахуйн салбарт учирч буй эрсдэлийг бууруулах талаар

төрөөс баримталж буй бодлого, өнөөгийн байдал” сэдэвт илтгэл,
Г.Наранчулуун

12. “Малын индексжүүлсэн даатгал” гарын авлага, 2009
13. “我国农业保险发展” 刘敏, 长春科技学院 2014
14. “浅析中国农业保险市场的开发” 国寿财险楚雄州中心支公司
2017 高敏媛
15. Agricultural insurance” Ramiro Iturrioz 2009 theWorldBank
16. “Crop insurance – risks and models of insurance” Vladimir Čolović,
Nataša Mrvić Petrović, Economics of Agriculture 3/2014
17. “3rd Asia Agriculture Insurance Conference” 2016, Сингапур
18. “Agricultural Insurance” P. K. Ray Second edition
19. “Government Support to Agricultural Insurance “ 2010, Mahul, Olivier,
Stutley, Charles J.